


Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын
даргын 2019 оны 03 дугаар сарын 05 ны өдрийн
А/08 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ



**АЛБАН ХААГЧДЫН ЧАДАВХЫГ
БЭХЖҮҮЛЭХ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР
2019-2020 ОН**

**БАГАНУУР ДҮҮРЭГ
2019 ОН**

**АЛБАН ХААГЧДЫН ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР
2019-2020 ОН**

АГУУЛГА

1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

- **АЛСЫН ХАРАА**
- **ЭРХЭМ ЗОРИЛГО**
- **ХӨТӨЛБӨРИЙН ЭРХЭМ ЗОРИЛГО**
- **ХӨТӨЛБӨРИЙН ЭРХ ЗҮЙН ҮНДЭС**

2. БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

3. АЛБАН ХААГЧДЫН СУРГАЛТЫН ХЭРЭГЦЭЭГ ТОДОРХОЙЛОН ХӨГЖҮҮЛЭХ

4. ХҮНИЙ НӨӨЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ГАДААД, ДОТООД ХАМТЫН АЖИЛЛАГААГ ХӨГЖҮҮЛЭХ

5. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

- **АЛБАН ХААГЧДЫН ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**
- **ПАРКААС ЗОХИОН БАЙГУУЛАХ СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**
- **ХҮНИЙ НӨӨЦИЙГ ЧАДАВХИЖУУЛАХ, ТОГТВОР СУУРЬШИЛТАЙ АЖИЛЛУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**
- **ПАРК СУРАЛЦАГЧ БАЙГУУЛЛАГА БОЛОХ ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

- **АЛСЫН ХАРАА**

Олон улсын жишигт нийцсэн эко үйлдвэрлэлийн парк болно.

- **ЭРХЭМ ЗОРИЛГО**

Эрчимтэй хөгжлийн шинэчлэл нь үйлдвэрлэл технологийн парк байна.

- **ХӨТӨЛБӨРИЙН ЭРХЭМ ЗОРИЛГО**

Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн үндсэн чиг үүргийг үр нөлөөтэй хэрэгжүүлэх, байгууллагын өөрчлөлт шинэчлэлтэд зохицож чадах үнэт зүйл, мэдлэг чадвар бүхий менежментийн баг, хүний нөөцийг төлөвшүүлэхэд энэхүү хөтөлбөрийн эрхэм зорилго оршино.

- **ХӨТӨЛБӨРИЙН ЭРХ ЗҮЙН ҮНДЭС**

Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.13-т “төрийн байгууллагаас төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөр болон ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг арга зүйн удирдлагаар хангах”

Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 5-15 “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдын чадавхыг бэхжүүлэх сургалтын хөтөлбөр”-ийг батлуулж хэрэгжүүлнэ.

2. БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн А/757 дугаар захирамжаар Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын бүтэц, зохион байгуулалт, орон тооны дээд хязгаарыг баталсан.

Тус бүтэц зохион байгуулалтаар Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ нь 14 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй Багануур дүүрэгт үйлдвэрлэл, технологийн парк байгуулах бэлтгэл ажлыг хангах зорилгоор үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн.

2019 оны байдлаар үйлдвэрлэл, технологийн парк байгуулах бэлтгэл үе шатыг бүрэн хэрэгжүүлж дууссан. Паркийн үндсэн үйл ажиллагааг эхлүүлэх зорилгоор Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын даргын 2019 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/04 дүгээр тушаалаар бүтэц, орон тоо, ажлын чиг үүргийг шинэчлэн баталсан.

№	Албан тушаалын нэр	Орон тоо
УДИРДЛАГА		
1	Дарга	1
ЗАХИРГААНЫ АЛБА		
2	Ахлах мэргэжилтэн	1
3	Нягтлан бодогч	1
4	Хуулийн зөвлөх	1
5	Маркетинг, олон нийтийн харилцаа, хот хариуцсан мэргэжилтэн	1
6	Бичиг хэрэг, архив, гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн	1
7	Программ хангамж, бүртгэл, мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн	1
8	Нярав-үйлчлэгч	1
9	Жолооч	1
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН АЛБА		
10	Ахлах мэргэжилтэн	1
11	Үйлдвэрлэл, технологийн кластер инженер	1
12	Эрдэм шинжилгээ судалгааны зохион бүтээгч инженер	1
13	Төсөл, хөрөнгө оруулалтын эдийн засагч	1
14	Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөлт, дэд бүтцийн инженер	1
Нийт		14

3. АЛБАН ХААГЧДЫН СУРГАЛТЫН ХЭРЭГЦЭЭГ ТОДОРХОЙЛОН ХӨГЖҮҮЛЭХ

Байгууллагын албан хаагчид албан үүргээ хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай мэдлэг, ур чадварыг байнга, тасралтгүй эзэмшүүлэх, мэдлэг боловсролыг дээшлүүлэх, ажил хариуцах чадварыг сайжруулах замаар жишиг үйлдвэрлэл, технологийн паркийг байгуулах зорилгоор сургалтыг үе шаттайгаар явуулна. Үүнд:

- Албан хаагч нараас сургалтын санал авах
- Албан хаагч нарын сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох
- Ажлын байрны зураг авалтыг зохион байгуулж, чиг үүргийн шинжилгээ хийх
- Албан хаагчдад чиглэсэн сургалтын төлөвлөгөөг баталж хэрэгжүүлэх
- Архив, албан хэрэг хөтлөлтийн сургалтыг хэвшүүлэх, мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх чиглэлд анхаарах
- Албан хаагчдыг ажлын байранд мэргэшэх боломжийг хангаж сэлгэн ажиллуулах
- Албан хаагчдын ажилласан жил, дадлага туршлага, мэргэжлийн онцлог дээр тулгуурлан гадаад оронд болон олон улсын жишгээр мэргэшүүлдэг дотоодын сургалтад хамруулах
- Албан хаагчдын туршлагаас шинэ залуу албан хаагчдад практик сургалт явуулах боломжийг бүрдүүлэх
- Төр захиргааны байгууллагуудаас зохион байгуулах төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус сургалтуудад тасралтгүй хамруулах
- Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн өөрчлөлт шинэчлэлийн мэдлэгийг тухай бүр олгох

4. ХҮНИЙ НӨӨЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ГАДААД, ДОТООД ХАМТЫН АЖИЛЛАГААГ ХӨГЖҮҮЛЭХ

Тус байгууллагын хүний нөөцийн бодлогод гадаад, дотоод хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр түлхүү анхаарч ажиллах нь зүйтэй. Хүний нөөцийн мэргэжилтний мэдлэг ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр тодорхой ажлыг зохион байгуулна. Энэ нь тус байгууллагын албан хаагчдын хөгжилд тодорхой үр дүнтэй байна.

- Хүний нөөцийн удирдлага болон удирдах албан тушаалын манлайллын чиглэлээр холбогдох сургалтад хамрагдаж үр дүнд хүрэх
- Төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн хүний нөөцийн бодлого, зорилгын талаар судлах, харилцан туршлага судлах, мэдээлэл солилцох чиглэлээр хамтран ажиллах
- Олон улсын байгууллагаас хүний нөөцийг хөгжүүлэх чиглэлд мэргэшил арга зүйн дэмжлэг тусалцаа авах
- Хүний нөөцийн мэргэжилтэнг хүний нөөцийн чиглэлээр нарийн мэргэшүүлэх, холбогдох сургалтад хамруулах
- Бусад орны төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, чиг хандлагыг судлах, харилцан туршлага солилцох

5. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын 2019-2020 оны албан хаагчдын чадавхыг бэхжүүлэх сургалтын хөтөлбөрийн дагуу жил бүр дараах төлөвлөгөөнүүдийг батлан хэрэгжүүлж хөтөлбөрийг гүйцэтгэл, үр дүнг тооцно.

- Албан хаагчдын чадавхыг бэхжүүлэх сургалтын төлөвлөгөө
- Багануур үйлдвэрлэл, технологийн паркаас зохион байгуулах сургалтын төлөвлөгөө
- Хүний нөөцийг чадавхижуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах төлөвлөгөө
- Парк суралцагч байгууллага болох зорилтыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө

----О----